



“Өндөр гэгээний соёлын өвийг уламжлагч”, “Зохиолч багш”
уралдааны зардлын тооцоо

| д/д | Уралдааны нэр | тоо | Нэгж үнэ /Мян.төг/ | Нийт үнэ /Мян.төг/ |
|-----|--|-----|-----------------------|-----------------------|
| 1. | “Өндөр гэгээний соёлын өвийг уламжлагч” | 1 | 2000.000 | 2000.000 |
| 2. | “Зохиолч багш” Уралдааны шилдэг оролцогч | 20 | 100.000 | 2000.000 |
| 3. | “Өндөр гэгээний соёлын өвийг уламжлагч” уралдааны бусад зардал | | | 1000.000 |
| | ДҮН | | | 5000.000 |



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/253

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1а, 29.2, “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтийг хамарсан коронавирусын тархалттай холбогдуулан онлайнаар Өвөрхангай аймгийн урчууд, уран бүтээлчид, өвлөн уламжлагчдын дунд шилдэг бүтээл, уран бүтээлчдийг шалгаруулан “Өндөр гэгээний соёлын өвийг уламжлагч”-ыг тодруулан алдаршуулах, цахимаар сургалтын үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдуулан багш, сурагчдыг идэвхжүүлэх, бүтээлийг хойч үедээ таниулан сурталчилах хүрээнд “Зохиолч багш” уралдааныг тусгайлсан удирдамжийн хүрээнд зохион байгуулж, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), сумын Засаг дарга нар, соёлын байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.

2. “Өндөр гэгээний соёлын өвийг уламжлагч”, “Зохиолч багш” цахим уралдааны шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

3. Цахим уралдааны шагналд зарцуулагдах 5000,000 (таван сая) төгрөгийг Үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс(Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100562